



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/556

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1. дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн БШУЯ/202212109 дугаар гэрээтэй Чандмань сумын 75 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандахүү	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Н.Долгорсүрэн	("Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн бүс хариуцсан ахлах инженер)
	Э.Пүрэвжаргал	("Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн инженер)
	С.Энхбаяр	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад)
	О.Мөнхбаатар	(Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
	Д.Отгонжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Б.Батбилэг	(Газрын харилцаа, барилга, хот

	байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)
Ш.Ариунаа	(Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны аймаг дахь зөвлөлийн тэргүүн)
М.Нансалмаа	(Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Д.Цолмон	(Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга)
П.Лханзмаа	(Чандмань сумын цэцэрлэгийн эрхлэгч)
Э.Алтан-Оргил	("Хурд хүч чадал" ХХК-ийн Чандмань салбарын захирал) (хангагч)
Д.Баярчулуун	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ерөнхий инженер) (хангагч)
Д.Цэвэлмаа	("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер) (хангагч)
Ч.Нарандэлгэр	("Барилга байгууламж" ХХК-ийн захирал) (зохиогч)
Ш.Соронзонболд	("Буман хаус" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга: Г.Бат-Эрдэнэ	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдэлтэй нийцүүлэн шалгаж, хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Чандмань сумын цэцэрлэг (П.Лханзмаа)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ